

# Бэрз байрлуулалт

Доор үзүүлсэн 6x6 хэмжээтэй шатрын хөлгөнд анхаарлаа хандуулна уу. Тэгээд 6 ширхэг бэрзийг мөр болон багана бүрт цор ганц бэрз байхаар өрсөн байгааг анхаар. Мөн аль ч диагональ дээр нэгээс олон бэрз байрлуулаагүй байгаа. (Диагональ нь зүүн дээрээс баруун доод булан руу, баруун дээд булангаас зүүн доод булан руу байх бүх диагональ, зөвхөн 2 том нь биш бүгд.)

Column	1	2	3	4	5	6
1						
2						
3						
4						
5						
6						

Дээрх хариу нь 2 4 6 1 3 5 гэсэн дарааллаар тодорхойлогдож байгаа бөгөөд 1-ээс 6 хүртэлх мөр бүрт бэрз хэд дүгээр баганад байрлахыг зааж байгаа юм.

ROW	1	2	3	4	5	6
COLUMN	2	4	6	1	3	5

Энэ бол бэрз байрлуулалтын нэг хариу/шийдэл юм. Бэрз байрлуулалтын бүх ялгаатай хариунуудын жагсаалтыг олох програм бич. Дээр үзүүлсэн баганы тэмдэглэгээг ашиглан хариуг хэвлэ. Бэрзнэй байрлалын жагсаалт дахь цифрүүдээр үүсэх тоон өсөхөөр нь дараалуулж эхний 3 хариуг хэвлэ. Тэгээд нийт боломжит хариуны тоог хэвлэ.

## ОРОЛТ

Бүхэл тоо  $N$  ( $6 \leq N \leq 13$ ). Энэ нь  $N \times N$  шатрын хөлгийн хэмжээс.

## ГАРАЛТ

Эхний 3 мөрөнд N ширхэг тоо нэг хоосон зайгаар тусгаарлагдан хэвлэгдэнэ. Эдгээр нь эхний 3 хариу байна. 4 дахь мөрөнд нийт хариуны тоо байна.

## ЖИШЭЭ

### ОРОЛТ

6

### ГАРАЛТ

2 4 6 1 3 5

3 6 2 5 1 4

4 1 5 2 6 3

4

Орчуулсан : Б.Даваабаяр